



## НИЙСГЭЛГИЙН ӨМЧИЙН ХАРИЛЦААНЫ ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2025 оны 06 сарын 00 өдөр

Дугаар А/152.

Улаанбаатар хот

「 Хан-Уул дүүргийн 67 дугаар цэцэрлэгийн  
данс бүртгэлд эргэлтийн бус хөрөнгө бүртгэх тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсгийн 4 дэх заалт болон 75 дугаар зүйлийн 75.1 дэх хэсэг, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолоор батлагдсан “Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журам”-ын 1 дүгээр зүйлийн 1.3 дахь хэсэг, 3 дугаар зүйлийн 3.2.3 дахь заалт, Нийслэлийн Өмчийн харилцааны газрын даргын 2025 оны А/126 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан “Үндсэн хөрөнгийн хөдөлгөөн хариуцсан комисс”-ын 2025 оны 6 дугаар сарын 27-ны өдрийн 5 дугаар хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Тус цэцэрлэгийн эцэг эхчүүдээс хандивласан нийт 7,823,900.00 (долгоон сая найман зуун хорин гурван мянга есөн зуу) төгрөгийн үнэ бүхий хавсралтад заасан эргэлтийн бус хөрөнгийг данс бүртгэлдээ бүртгэн авахыг Хан-Уул дүүргийн 67 дугаар цэцэрлэг (С.Цолмон)-т зөвшөөрсүгэй.
2. Өмчийн мэдээллийн санд хөрөнгийн хөдөлгөөний холбогдох өөрчлөлт хийж ажиглахыг Хан-Уул дүүргийн 67 дугаар цэцэрлэг (С.Цолмон)-т үүрэг болгосугай.
3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиглахыг Захиргаа удирдлагын хэлтэс (Т.Оюунтуул)-т даалгасугай.

ДАРГА



В.ОЮУМАА



Нийслэлийн Өмчийн харилцааны газрын  
2025 оны 06 дугаар сарын 06-ны  
өдрийн 06 дугаар тушаалын хавсралт



Эргэлтийн бус хөрөнгийн дансанд бүртгэх хөрөнгийн жагсаалт

Байгууллагын нэр: Хан-Уул дүүргийн 67 дугаар цэцэрлэг

№	Эд хөрөнгийн нэр	Марк дугаар	Ашиглалтад авсан огноо	Чанар байдал	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Бүртгэх анхны		Хандивлагч байгууллага		
							Нэгжийн үнэ	Нийт үнэ	нэр	Эх үүсвэр	
1	Аяга таваг угаагч	Daewoo	1/10/2024	сайн	ш	1	899,900.00	899,900.00	Эцэг эхчүүд	Хандив	
2	Зурагт	Haier 43	1/10/2024	сайн	ш	1	799,000.00	799,000.00			
3	Ус цэвэршүүлэгч	Pure Pro	1/10/2024	сайн	ш	1	700,000.00	700,000.00			
<b>Машин тоног төхөөрөмжийн дүн</b>						<b>3</b>		<b>2,398,900.00</b>			
4	Хивс	Хятад	1/10/2024	сайн	м	2	630,000.00	1,260,000.00	Эцэг эхчүүд	Хандив	
5	Хивсэн дроз	Орос	1/10/2024	сайн	м	10.5	170,000.00	1,785,000.00			
6	Дроз	Хятад	1/10/2024	сайн	м	13.5	176,300.00	2,380,000.00			
<b>Тавилга эд хогшлын дүн</b>						<b>26.0</b>		<b>5,425,000.00</b>			
<b>Нийт бүртгэх хөрөнгийн дүн</b>								<b>7,823,900.00</b>			